



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

Эх барих, эмэгтэйчүүд, нярайн
тусламжийн чанарыг сайжруулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Мянганы хөгжлийн дөрөв, тав дахь зорилтод хүрсэн үр дүнг тогтвортой байлгах, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2012 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 4 дэх хөтөлбөр 2012-2016", "Эх, нярайн эрүүл мэнд стратеги 2011-2015"-ийн хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээний чиглэлээр аймаг, дүүргүүдийг хариуцан ажиллах мэргэжилтнүүдийн хуваарийг нэгдүгээр, орон нутагт ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хариуцсан орон нутгуудад дэмжин туслах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг орон нутаг хариуцсан эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд болон эмч, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

003008

126
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 сарын 13 өдрийн
474 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД
ЭМЧ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ОРОН НУТГИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/Д	Аймгийн нэр	Аймгийн нэр	Хариуцах мэргэжилтэн
1.	Архангай	Дундговь	Ч.Мөнхбаяр, ЭХЭМҮТ
2.	Баянхонгор	-	Г.Мэндсайхан, ЭМШУИС
3.	Баян-Өлгий	Сүхбаатар	Д.Янжинсүрэн, ЭМШУИС
4.	Булган	Говь-Алтай	Г.Баттулга, ЭХЭМҮТ
5.	Говьсүмбэр	Хөвсгөл	Я.Батцэрэн, ЭХЭМҮТ
6.	Дархан-Уул	-	Ц.Үржиндэлгэр, ЭХЭМҮТ
7.	Дорнод	-	Д.Мөнхцэцэг, ЭМШУИС
8.	Дорноговь	-	Ж.Энхцэцэг, ЭМШУИС
9.	Завхан	Хэнтий	С.Хишгээ, ЭХЭМҮТ
10.	Орхон	-	Ж.Энхтуяа, ЭХЭМҮТ
11.	Өвөрхангай	Ховд	Т.Эрхэмбаатар, ЭМШУИС
12.	Сэлэнгэ	Увс	Т.Сарантуяа, ЭХЭМҮТ
13.	Өмнөговь	-	Г.Дашзэвгэ, ЭХЭМҮТ
14.	Төв	-	Я.Хишигсүрэн, ЭХЭМҮТ
15.	Улаанбаатар	-	Д.Дариймаа, зөвлөх эмч Б.Бүлтэн, зөвлөх эмч

Тайлбар: Аймаг хариуцсан мэргэжилтэнг сонгохдоо ЭМЯ-ны мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон ЭХЭМҮТ-ийн эмч мэргэжилтэнг сонгосон болно.

127
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 сарын 13 өдрийн
474 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮД НЯРАЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго.

Эх барих, эмэгтэйчүүдийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, мэргэжлийн аргазүйн чиглэлээр дэмжин, туслах

Зохион байгуулах газар.

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эмнэлгийн тусламжийн хэлтэс

Санхүүжилт.

Эрүүл мэндийн яам, орон нутгийн Эрүүл мэндийн газар, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

1. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй журам, заавар, тушаалын хэрэгжилтийг хянах;
2. Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний байдалтай танилцах, зөвлөгөө өгөх,
3. Эх, нярайд үзүүлэх тусламжийн байнгын бэлэн байдал, удирдамж жишгийн мөрдөлтийг хянаж зөвлөгөө өгөх;
4. Орон нутагт мэргэжлийн чиглэлээр ажлын байран дахь сургалт зохион байгуулах;
5. Хариуцсан орон нутагт эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламжийн зохион байгуулалтын болон төрөлжсөн мэргэжлийн тусламжийг үзүүлэх;
6. Эх эндсэн тохиолдолд орон нутагт ажиллаж, цаашид уг алдааг давтахгүй байх зөвлөмжийг боловсруулах;

7. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргагч нарт танилцуулж, шийдвэр гаргахад нөлөөлөх;

8. Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах;

9. Орон нутгийн эх барихын ерөнхий мэргэжилтэн, НҮЭМ-ийн зохицуулагч болон эмч нартай байнгын уялдаа холбоотой ажиллаж зөвлөгөө өгөх;

Үр дүн:

1. Аймаг, дүүргүүдийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар, тэгш байдал сайжирна.

2. Эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээрх эмч, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирна.

Үүрэг.

1. Орон нутагт ажиллах бүртээ зөвлөмж бичиж, Эрүүл мэндийн газрын удирдлага, эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэнд хүлээлгэж өгнө.

2. Орон нутагт томилолтоор ажилласан тухай үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг томилолт дууссанаас хойш ажлын 03 хоногийн дотор Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлнэ.

3. Хариуцсан аймаг, дүүргийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламжийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлнэ.